

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын  
11-ний өдрийн 255 дугаар тогтоолоор баталсан  
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт  
“Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал болон тухай бүр  
мэдээлэх мэдээллийн агуулга, хэлбэр”-ийн Жилийн  
үйл ажиллагааны тайлагнал маягт I

<b>Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт I/</b>	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа	<p>2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр</p>
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<p>Нэр: Ард Кредит ББСБ ХК УБГД: 9010002003 ҮЦК: ADB Утас: +976 77003322</p>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк бус санхүүгийн байгууллага
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Грант Торнтон Аудит ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	280,000,000 (хоёр зуун наян сая) ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p><b>Бэлтгэсэн:</b> ТУЗНБД Д.Мөнх-Од Санхүүгийн шинжээч Ш.Пүрэвдорж <b>Хянасан:</b> Гүйцэтгэх захирал: Г.Тэлмэн Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир</p>
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

		Үзүүлэлт (мянган төгрөг)	Эхний үлдэгдэл (1-р сарын 1)	Эцсийн үлдэгдэл (12-р сарын 31)
<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>		Хөрөнгө		
		Эргэлтийн хөрөнгө	56,447,149	68,400,002
		Эргэлтийн бус хөрөнгө	1,591,599	3,605,544
		<b>Нийт хөрөнгө</b>	<b>58,038,748</b>	<b>72,005,547</b>
		Өр төлбөр ба эздийн өмч		
		Өр төлбөрийн нийт дүн	39,989,326	51,100,637
		Эздийн өмч	18,049,422	20,904,909
		<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>58,038,748</b>	<b>72,005,547</b>
		<i>Орлогын тайлан</i>		<b>Үзүүлэлт (мянган төгрөг)</b>
Хүүгийн орлого	11,339,294			13,019,411
Хүүгийн зардал	6,513,600			6,887,980
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>4,825,694</b>			<b>6,131,431</b>
Хүүгийн бус орлого	5,945,035			4,730,883
Хүүгийн бус зардал	6,335,565			7,672,701
Болзошгүй эрсдэлийн зардал	2,530,969			2,840,634
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	575,759			2,639,593
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	45,389			37,201
Татварын өмнөх ашиг	2,434,565			2,951,371
Орлогын татварын зардал	375,341			432,710
<b>Цэвэр ашиг</b>	<b>2,059,224</b>			<b>2,518,661</b>
1.1.	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>			
	Аудитын компаниас эерэг дүгнэлт өгсөн			
1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>			



"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК  
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
дэлхийн сүлжээний бие даасан фирм

## Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Долой талр 9 даяар, КНЭСКО  
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р  
 хороо, Улаанбаатар 14230,  
Монгол улс  
Т + 976 70 110748  
+ 976 70 110799

"Ард Кредит" ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид "Ард кредит ББСБ" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягт"-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул "Ард кредит ББСБ" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй болно.

### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

### Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

  
ГРАНТ ТОРНТОН  
АУДИТ  
Б.ООРЖИГАВАН  
УДИРДАХ ПАРТНЕР  
УЛААНБААТАР ХОТ  
11182/4951  
Монгол улс, Улаанбаатар хот  
2024 оны 3 дугаар сарын 28

www.grantthornton.mn

2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, уридлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан мэдээлэл			
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Үйл ажиллагааны ашгийн хувь	14.0%	
		Цэвэр ашгийн хувь	12.1%	

		Өөрийн хөрөнгийн өгөөж	12.9%
		Нийт хөрөнгийн өгөөж	3.9%
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 14.1% Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа (D/E) 1.9	
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	 <p><b>1.</b> Компанийн засаглалын кодексын үнэлгээний тайлангаар Хөрөнгийн биржийн I ангиллын ТОП-10 засаглал сайтай компанийн нэг болов.</p>  <p><b>2.</b> Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрөл авав.</p>  <p><b>3.</b> Монголбанкнаас Аутсорсингийн тусгай зөвшөөрөл авав.</p>  <p><b>4.</b> Зээлийн гэрээг Ард Аппаар баталгаажуулдаг болов.</p>  <p><b>5.</b> Анхны карт гаргагчийн тусгай зөвшөөрөл бүхий Кредит картыг хэрэглэнд нэвтрүүлэв.</p>	
2.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	Тэнцлийн гадуур дансанд хүлээж болзошгүй үүрэг хариуцлага, эрсдэлийн сангаас хаасан тооцоо, зээлийн барьцааны эд зүйлс, үнэ бүхий зүйлс ангилалаар бүртгэдэг. Тухайн тайланд хугацаанд тэнцлийн гадуур зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийн дүн 4.1 тэрбум төгрөг, хуримтлуулж тооцохыг зогсоосон зээл 101.0 сая төгрөг байна.	
2.5.	<i>Тайлан хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	Тайлант хугацаанд 94.7 сая төгрөгийн үндсэн зээлийн төлөлт хийлгэв.	
3.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлан хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>		

Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээллийг хөндлөнгийн аудитын “Холбоотой талууд” хэсэгт тогтмол нийтэд мэдээлдэг болно.

4. Цалин урамшууллын мэдээлэл

2023 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалинд 100 сая төгрөг, ТУЗ-ийн хурлын бэлтгэл ажил болон бусад зардалд 1.6 сая төгрөг зарцуулсан байна.

**Урамшууллын бодлого**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгохдоо тухайн жилийн ажлын гүйцэтгэл 50%, хурлын ирц 50%-иар тооцож жилд нэг удаа урамшуулал олгодог.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

**Засаглалын бүтэц, үйл ажиллагаа**

Ард Кредит ББСБ ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана.

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 6 ердийн гишүүн 3 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй сонгогдсон ба Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн Гүйцэтгэх захирал, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Дотоод аудиторыг тус тус томилон ажиллаж байна. Гүйцэтгэх захирал нь компанийн удирдлагын чиг үүрэг, өдөр дутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилладаг.

**Компанийн бүтэц 2023 онд**



## Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт Сэнтрал тауэр барилгын 17 давхарт Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд зохион байгуулагдав. Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулвал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлав.

## Төлөөлөн Удирдах Зөвлөл

### Ердийн гишүүд:



#### Ч.ГАНЗОРИГ

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга  
Бизнес менежмент мэргэжилтэй  
Ай Дакс ХХК-ийн Гүйцэтгэх захирал,  
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.17%-ийн хувьцаа эзэмшдэг



#### О.ОДБАЯР

Багш, эрх зүйч мэргэжилтэй  
Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга  
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.01%-ийн хувьцаа эзэмшдэг



#### Б.ГАНБАТ

Санхүү, эдийн засагч мэргэжилтэй  
Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.05%-ийн хувьцаа эзэмшдэг



#### Г.УЯНГА

Банк, санхүүч мэргэжилтэй  
Ард Пропертиз ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.09%-ийн хувьцаа эзэмшдэг



#### Г.ТЭЛМЭН

Менежмент, ОУЭЗасагч мэргэжилтэй  
Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал  
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.09%-ийн хувьцаа эзэмшдэг



#### Б.ЗОЛБОО

ОУНББ, АССА, Эдийн засагч мэргэжилтэй  
Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал  
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.11%-ийн хувьцаа эзэмшдэг

**Хараат бус гишүүд:**



**В.ГАНЗОРИГ**

Мэргэшсэн нягтлан бодогч мэргэжилтэй, МВА  
СЕО клубын ерөнхийлөгч  
Бат Солюшн Партнерс ХХК-ийн ТУЗ-ийн дарга  
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.03%-ийн хувьцаа эзэмшдэг



**Б.СОЛОНГО**

Нягтлан бодогч, Аудитор, мэргэжилтэй  
Софтлайн Азия ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
Онсь Рүүм-н үүсгэн байгуулагч Триквест ХХК-ийн Гүйцэтгэх  
захирал  
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.01%-ийн хувьцаа эзэмшдэг



**С.ЭНХЧИМЭГ**

Бизнес менежмент мэргэжилтэй  
Бипрос Монголиа ХХК-ийн үүсгэн байгуулагч  
Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй

**Гүйцэтгэх удирдлагын баг**



**Г.ТЭЛМЭН**  
Гүйцэтгэх захирал



**Г.СҮХБААТАР**  
Бизнес хөгжил  
эрхэлсэн захирал



**Д.ЛХАГВА-ОЧИР**  
Санхүү эрхэлсэн  
захирал



**А.ДУНИМ**  
Дижитал хөгжил  
эрхэлсэн захирал

б. *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл*

Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, бусад оролцогч талууд нь бидний бизнест үүсэх эрсдэлд шууд болон шууд бусаар өртөх боломжтой байдаг тул бидний зүгээс хариуцлагын хүрээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог алба, нэгж бүртээ бүрдүүлэн ажиллаж ирсэн. Байгууллагын дотоод соёл, уур амьсгал нь нийт ажиллагсдын зан төлөв хандлагыг төлөвшүүлдэг. Энэ нь ажиллагсад эрсдэлд хэрхэн хандах, ямар хэмжээний эрсдэл хүлээн зөвшөөрөх, эрсдэлийг хэрхэн удирдах зэрэгтэй шууд хамааралтай. Тиймээс бид байгууллагын соёлдоо ажилтан нэг бүр эрсдэлийн удирдлагад хариуцлагатай хандаж, өөрсдийн ажлын дээрх эрсдэл нэг бүрийг тооцоолон ажиллах хэв маягийг бүрдүүлж ажиллаж байна.

Бид тулгарч болзошгүй эрсдэлүүдийг макро эдийн засаг, бодлогын хүүгийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон зээлийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, тусгай зөвшөөрлийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны шаардлага, Монголбанкны бодлогын хүрээ, мэдээллийн аюулгүй байдал, кибер халдлага, бизнесийн салбарын орчин, санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэхэд үүсэж болзошгүй эрсдэл зэргээр эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлээс урьдчилан

сэргийлэх, эрсдэлийг арилгах, багасгах арга хэмжээнүүдийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлж байна.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд ТУЗ ба ТУЗ-ийн дэргэдэх хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Дотоод аудитын хороо;
2. Санхүү, зээл, эрсдэлийн хороо;
3. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо.

ТУЗ-өөс Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг баталж, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшинг тодорхойлох ба хэрэгжилтэд хяналт тавина. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж гүйцэтгэх удирдлагад хяналт тавьж ажиллаж байна.

7. *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/*






8. *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл*

Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд хувьцаа санал болгоогүй болно.

9. **Ногдол ашгийн мэдээлэл**

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02 сарын 14-ны өдрийн 2024/04 тоот тогтоолоор компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 2.8 (хоёр аравны найм) төгрөг буюу цэвэр ашгийн дүнгээс 1,019,200,000 төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.



	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 сарын 5-ны өдрөөр тогтоосон ба 2024 оны 4 сарын 22-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны өгсөн зөвлөмжийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд шилжүүлсэн.
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Хөрөнгө Оруулагч Үндэстэн – Праг, Солонгос арга хэмжээнүүдийг зохион байгуулж хилийн чанадад оршин суугаа Монголчууддаа санхүү хөрөнгө оруулалтын сургалт, мэдээ мэдээллийг түгээн ажиллав. #БидИлүүБайжЧадна аяныг хамтран хэрэгжүүлж аяныг эхлүүлснээс өдгөө Монгол Улсын 52,515 хүүхдийг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч болгов. Хүүхдийн баярды тохиолдуулан ерөнхий боловсролын 29, 116 дугаар сургуулиуд дээр зочилж сурагч хүүхдүүдэд хүүхдийн баярын бэлэг болон “Ирээдүйн Эзэн” хүүхдийн хадгаламжийн эрхийн бичиг гардуулав.
<i>Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</i>	
Гүйцэтгэх захирал Д.Сүхбаатар 	Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир 
<i>Мэдээлэл бэлтгэгч, хуралдсан этгээдийн гарын үсэг, огноо:</i>	
Овог, нэр: Д.Мөнх-Од Албан тушаал: ТУЗНБД Гарын үсэг: 	



## Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2023 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
<b>Хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,223,162	5,027,668
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,358,464	789,329
Харилцагчдад олгосон зээл	47,941,596	40,038,098
Бусад санхүүгийн хөрөнгө	3,327,068	2,855,132
Бусад эргэлтийн хөрөнгө	8,549,712	7,736,922
Үндсэн хөрөнгө	867,847	938,892
Биет бус хөрөнгө	2,737,697	652,707
<b>Нийт хөрөнгө</b>	<b>72,005,546</b>	<b>58,038,748</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	15,133,326	11,211,776
Өрийн бичгээрх өглөг	-	6,886,000
Хойшлогдсон татварын өр төлбөр	103,722	
Бусад эх үүсвэр	24,161,193	13,641,277
Бусад өр төлбөр	11,702,396	8,250,273
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>51,100,637</b>	<b>39,989,326</b>
<b>Эздийн өмч</b>		
Эзэмшигчдийн өмч	8,152,792	8,152,734
Бусад өмч	1,915,611	1,598,872
Хуримтлагдсан ашиг	10,836,506	8,297,816
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>20,904,909</b>	<b>18,049,422</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>72,005,546</b>	<b>58,038,748</b>

## Ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	2023 он	2022 он
Хүү болон түүнтэй адилтгах орлого	13,019,411	11,339,294
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(6,887,980)	(6,513,600)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>6,131,431</b>	<b>4,825,694</b>
Хүүгийн бус орлого	4,730,883	5,945,035
Хүүгийн бус зардал	(7,672,701)	(6,335,565)
<b>Цэвэр хүүгийн бус орлого</b>	<b>(2,941,818)</b>	<b>(390,530)</b>
Болзошгүй эрсдэлийн зардал	(2,840,634)	(2,530,969)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,639,593	575,759
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(37,201)	(45,389)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>2,951,371</b>	<b>2,434,565</b>
Орлогын татварын зардал	(432,710)	(375,341)
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>2,518,661</b>	<b>2,059,224</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	308,643	(10,365,666)
Бусад дэлгэрэнгүй орлогын нэмэгдэл	308,643	(10,365,666)
Хэрэгжсэн олз		-
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>2,827,304</b>	<b>(8,306,442)</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг</b>	<b>0.009</b>	<b>0.007</b>